



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/479

Булган сум

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын бэлтгэл ажлын хүрээнд сурталчилгааны туг, хулдаасан хэвлэл, биет үсгэн самбар хийлгэх аж ахуй нэгж, байгууллага, иргэн, шаардагдах зардал 20.608.300 (хорин сая зургаан зуун найман мянга гурван зуу) төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулж, хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллан, хүлээж авахыг Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Г.Алтанцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Шаардагдах хөрөнгийг орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



В.АРИУН-ЭРДЭНЭ

6324010629

20<sup>24</sup> оны 07 сарын 01... өдрийн 1/479 тоот  
Захирамжийн хавсралт



**СУРТАЛЧИЛГААНЫ ТУГ, АНОНС, БИЕТ ҮСГЭН САМБАР  
ХИЙЛГЭХ ТӨСВИЙН ЗАДАРГАА**

№	Зардлын нэр	Гүйцэтгэгчийн нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Сурталчилгааны туг	Г.Ариун-Эрдэнэ	282ш	30000	8,460,000
2	Туг өлгөх тогтоогч	Г.Чулуун-Эрдэнэ	282ш	9000	2,538,000
3	Сурталчилгааны хулдаасан хэвлэл	"Хангай Пресс" ХХК	202,6 м.кв	12000	2,431,200
4	Эх бэлтгэл	"Хангай Пресс" ХХК	10	50000	500,000
5	Хулдаасан хэвлэл тогтоох олс	Г.Гантуяа	100м	1500	150,000
6	Хулдаасан хэвлэл тогтоох чансаа	Хангай барилгын материалын дэлгүүр	2 боодол	55000	110,000
7	Биет үсгэн самбар	"ИЕРЕМИА" ХХК	1ш	5,688,300	5,688,300
8	Шатахуун	"Петровис" ШТС	210 л	3480	730800
<b>Нийт дүн</b>					<b>20,608,300</b>